

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ2022 оны 12 сарын 28 өдөрДугаар: 34

Улаанбаатар хот

Төлөвлөгөөний биелэлт
дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 13 дугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 4.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн “Үндэсний давхар даатгал” ХК нь 2022 оны давхар даатгалын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэсүгэй.

2. 2022 оны давхар даатгалын төлөвлөгөөний биелэлт, холбогдох тайланг “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-д заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхланта)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ